



2026 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

"ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХК

1

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загвар

2

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулах асуудлууд

- 2025 оны санхүү, үйл ажиллагааны тайлан
- 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр

3

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал

- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах

4

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загвар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59.1, 59.4, 60.1 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Инновэйшн инвестмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 15:00 цагт /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 1 дүгээр хавсралтаар баталж, мэдээг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонин, олон нийтийн телевизийн мэдээгээр хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисс-т даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 2 дугаар хавсралтаар баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай. 3 дугаар хавсралтад заасан бичиг баримтыг үнэт цаасны компаниуд, мөн компанийн албан ёсны цахим хуудсаар болон хурал зохион байгуулах комисс, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар ердийн аргаар санал авах саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.
8. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр болон Хувьцаа эзэмшигч өөрийн харилцдаг брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Компанийн өөрийн байранд буюу Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, НМ төв, 8 давхар хаягт урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба санал авах сүүлийн хугацаа нь 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цаг байна.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Б.Энхболд, гишүүнээр О.Маралмаа, хурлыг зохион байгуулах комиссын нарийн бичгийн даргаар П.Мөнхтуяа нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын дарга А.Баттамир, тооллогын комиссын даргаар “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Харилцагчийн албаны захирал Б.Онон, тооллогын комиссын гишүүнээр “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Б.Хулан, М.Оюунсүвд нарыг тус тус томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус хүргүүлэх болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компанид хүргүүлэх, түүнтэй танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Энхболд)-д даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (О.Маралмаа)-д даалгасугай.

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Иновэйшн инвестмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 30-ны өдөр 15:00 цагт /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Цахим хурал зохион байгуулах холбоос: <https://agm.mn/>

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:
2026 оны 04-р сарын 10-ны өдөр

Хурлаар танилцах асуудлууд:

- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.

Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид урьдчилж саналаа өгөхдөө /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр болон өөрийн харилцдаг брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Компанийн өөрийн байранд буюу Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, НМ төв, 8 давхар хаягт биеэр ирж цаасаар өгөх боломжтой. Урьдчилан санал авах сүүлчийн хугацааг 2026 оны 04 сарын 29-ний өдрийн 15:00 цагаар тасалбар болгоно.

Аж ахуй нэгжийг төлөөлөн итгэмжлэлээр хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл хурал зохион байгуулах комисстой урьдчилан холбогдон тодруулага, мэдээлэл авна уу.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

ХОЛБОО БАРИХ: 75551919, 99907664, 88004829

МЭЙЛ ХАЯГ: BOARDSECRETARY@QPAY.MN

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 26/05 тоот тогтоолын
2 дугаар хавсралтаар батлав.

Хугацаа	Хөтөлбөр	Хариуцах
15:00-15:10	Хурлын ирцийг бүртгэх	Тооллогын комисс
15:10-15:15	Хурлын ирцийг мэдээлэх	Тооллогын комисс
15:15-15:20	Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга
15:20-15:40	Хурлаар танилцуулах асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах: <ul style="list-style-type: none">Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлтийг танилцуулахНогдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах	Гүйцэтгэх захирал Б.Энхболд “Мүүрь Аудит” ХХК-ийн аудитор ТУЗ-ийн дарга
15:40-16:00	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах: <ul style="list-style-type: none">Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай.	Хурлын дарга
16:00-16:20	Асуулт, хариулт, санал	
16:20-16:40	Санал хураалт	
16:40-16:50	Хурлын завсарлага	
16:50-17:00	Санал хураалтын нэгдсэн дүнг гаргаж, дүнг танилцуулах	Тооллогын комисс
17:00-17:10	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	Хурлын дарга
17:10-17:15	Хурлыг хаах	Хурлын дарга

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ТАНИЛЦУУЛАХ АСУУДЛУУД

- 2025 оны санхүү, үйл ажиллагааны тайлан
 - 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт
 - Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр



2025 ОНЫ

САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. БИДНИЙ ТУХАЙ

1. Компанийн тухай
2. Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйл
3. Бидний түүх
4. Групп Компанийн бүтэц
5. Гүйцэтгэх удирдлагын баг
6. Гүйцэтгэх захирлын захидал
7. Хувьцааны мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн бүтэц

3. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт
2. Санхүү байдлын тайлан
3. Орлого үр дүнгийн тайлан
4. Өмчийн өөрчлөлтийн тайлан
5. Мөнгөн гүйлгээний тайлан

2. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. QPAY- н эко систем
2. Бэлэн бус төлбөр тооцооны зах зээл эзлэлт
3. QPAY- н тоон үзүүлэлтүүд
4. Онцлох санхүүгийн үзүүлэлтүүд
5. Онцлох ажлууд
6. IPO хийх үеийн төсөөлөл ба гүйцэтгэл
7. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт
8. Нийгмийн хариуцлага

4. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

1. Төлөөлөн удирдах зөвлөл
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан
3. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай
4. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт
5. Ногдол ашгийн мэдээлэл

БИДНИЙ ТУХАЙ

1. Компанийн тухай
2. Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйл
3. Бидний түүх
4. Групп Компанийн бүтэц
5. Гүйцэтгэх удирдлагын баг
6. Гүйцэтгэх захирлын захидал
7. Хувьцааны мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн бүтэц

[MSE:QPAY] Ерөнхий мэдээлэл

Нэр:	Иновэйшн Инвестмент ХК (QPAY)
Регистрийн дугаар:	6183948
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:	Монголын Хөрөнгийн бирж
Ангилал:	II
Нийт эргэлтэнд гаргасан хувьцааны тоо ширхэг:	184,889,160
Бизнесийн чиглэл:	Мэдээлэл технологийн үйл ажиллагаа Программ хангамжийн үйлчилгээ



Иновэйшн Инвестмент ХК

Иновэйшн Инвестмент ХК нь 2017 оноос хойш технологийн хурдацтай хөгжилд тулгуурлан иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маягийг хялбаршуулах зорилго бүхий санхүү, төлбөр тооцоо, мэдээлэл технологийн чиглэлээр шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт менежментийн чиглэлээр үүсгэн байгуулагдсан нээлттэй хувьцаат компани юм.

100%



"ККТ" ХХК

Монгол банкны тусгай зөвшөөрлүүдийг авч бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, цахим хэтэвч, аппликэйшн хөгжүүлэх болон бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд шаардлагатай дэд бүтэц хөгжүүлэх чиглэлээр Монголд болон Олон улсад үйл ажиллагаа явуулж байна.

100%



"Дижитал Мерчант Сервисэс" ХХК

Мерчантад зориулсан аппликэйшн, санхүүгийн менежмент, зээл зуучлал болон зар сурталчилгааны финтек шийдэл буюу SaaS хөгжүүлэх, группийн мерчантын баазыг ханган өргөжүүлж, тэдэнд шаардлагатай нэмэлт үйлчилгээг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС



АЛСЫН ХАРАА

Хүний амьдралыг таатай болгох дижитал шийдэлд хөрөнгө оруулалт хийж, тогтвортой ирээдүйг бүтээх үйлсэд хувь нэмрээ оруулна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Технологид суурилсан инновацлаг шийдэлд зохистой хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, шинэ үеийн нийгэм, хүмүүсийн амьдралын хэв маягт нийцсэн дижитал дэд бүтцийг бүрдүүлэх үйлсийг манлайлна.



ҮНЭТ ЗҮЙЛС

- Тэмүүлэл
- Хүчтэй түншлэл, харилцаа
- Багийн ажиллагаа
- Хариуцлага
- Ухаалаг
- Хэрэгцээг ойлгодог
- Тэнцвэртэй байдал
- Тогтвортой хөгжил

БИДНИЙ ТҮҮХ

2016

Хаан банканд анхны нэвтрүүлэлт хийгдэхээр тохиролцож QR код уншуулан гүйлгээ хийх анхны хөгжүүлэлт хийгдэв.

2017

Анхны хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхээр группийн толгой компанийг буюу "Инновэйшн Инвестмент" ХК-ийг үүсгэн байгуулав.

2018

Төлбөр хүлээн авагч мерчант байгууллага болон Хэрэглэгчийн систем нийлүүлэгчид зориулсан QR нэхэмжлэх үүсгэх боломжтой API-ийн version 2.0 хувилбарыг нэвтрүүлэв

2019

Pos/кассын систем хөгжүүлэлт буюу Хэрэглэгчийн систем нийлүүлэгч компаниудад зориулан шинэчилсэн шинэ POS API хөгжүүлж нэвтрүүлэв.

2023

Технологийн салбарын анхны IPO-г амжилттай хийлээ.

2022

Дэлхийн 64 улсад нэвтэрсэн БНХАУ-ын хамгийн өргөн хэрэглээтэй цахим төлбөрийн систем болох олон улсын WechatPay үйлчилгээтэй экосистемийн гэрээ байгуулж Монгол улсдааанхлан нэвтрүүлэв. Олон улсын картын Unionpay үйлчилгээтэй хамтын ажиллагааг эхлүүлж картын системд холбогдов.

2020

QR нэхэмжлэх үүсгэх мерчантын шинэ API version 2.0 хувилбарыг нэвтрүүлэв.


2024

IPO хийснээс хойш 1 жилийн дотор ангилал ахиж МХБ-ийн II ангилалд арилжаалагдаж эхлэв. Ази, европын 24 улсад нэвтэрсэн БНСУ-ын №1 цахим төлбөрийн систем болох GLN International-тэй хамтран БНСУ-ын жуулчид эх орондоо хэрэглэдэг төлбөрийн апп-аараа Монголд QRay QR кодыг уншуулан төлбөрөө шууд хийх үйлчилгээг нэвтрүүлэв.

2025

Монголын хөрөнгийн биржийн **ТОП 20** индексийн багцад шинээр нэмэгдлээ.

ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Б. ЭНХБОЛД

CEO

2025 оны 7 сараас эхлэн "Инновэйшн Инвестмент" ХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.



Б.ЧУЛУУНСҮХ

ЗӨВЛӨХ

2025 оны 4 сараас эхлэн Инновэйшн инвестмент ХК-ийн зөвлөхөөр ажиллаж байна.



Н. ЖАВХЛАН

CEO

2025 оны 7 сараас эхлэн "ККТТ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.



С. ГҮРЖАВ

CEO

2019 оноос "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа.



О.ХОНГОР

СВО

2022 оноос Бизнес хөгжил хариуцсан захирлаар ажиллаж байгаа.



Д.ЖАНЧИВ

СТО

2021 оноос Технологи хариуцсан захирлаар ажиллаж байгаа.



Ц.ГОМБОДОРЖ

СИО

2022 оноос Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирлаар ажиллаж байгаа.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэт хэрэглэгч та бүхний амар амгаланг эрэн мэндчилье. 2025 онд “Инновэйшн Инвестмент” ХК-ийн хувьд өсөлтөө бататгаж, байр сууриа бэхжүүлсэн онцлох жил байлаа. 2025 онд борлуулалтын орлого 38.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 45 хувиар өсөж, цэвэр ашиг 13.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 34 хувиар өссөн, мөн өөрийн хөрөнгө 30.9 тэрбум төгрөгт хүрч 103 хувиар өссөн нь компанийн санхүүгийн чадавх, тогтвортой байдлыг улам бэхжүүллээ.

Үйл ажиллагааны хувьд 2025 онд бид дижитал төлбөрийн экосистемээ өргөжүүлж, Qra үйлчилгээгээр нийт 16.3 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 250 сая ширхэг гүйлгээг дамжуулсан нь Монгол улсын бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн гүйлгээний 11.0 хувьд, үнийн дүнгийн 2.5 хувьд тус тус хүрлээ.

Дижитал бизнес, технологийн зах зээлд амжилттай ажиллах үндэс нь эдийн засагт оруулж буй хувь нэмэр, нийгмийн ачааллыг технологийн аргаар хэрхэн хөнгөвчилж буй үнэ цэнээр тодорхойлогдог бөгөөд энэ хүрээнд бид үйл ажиллагаагаа өргөжүүлэн технологийн салбарт уламжлалт эдийн засагт инновац авчрах нөлөө бүхий, нийгэмд хүртээмжтэй шийдлийг бүтээх дараагийн хөрөнгө оруулалтаа хийж эхэлж байна.

“... Дижитал төлбөр тооцооны салбар эрчимтэй хөгжиж буй энэ үед бид хэрэглэгчдэд ээлтэй, хялбар, аюулгүй дижитал туршлагад хөрөнгө оруулах, тасралтгүй сайжруулахын зэрэгцээ хөрөнгө оруулагчдад тогтвортой өсөлт, үнэ цэнийг бий болгож, зах зээлд итгэл даасан, нэр хүндтэй оролцогчийн байр сууриа бэхжүүлэхэд төвлөрөн ажиллах болно”

2026 онд Хувьцаа эзэмшигчиддээ 2025 оны цэвэр ашгийн 69 хувийг, нийт 9.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд 2023 оны IPO-оос эхэлсэн бидний өсөлтийн замнал 2025 онд Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекст багтсанаар дараагийн шатандаа шилжсэн. Энэхүү амжилт бол бидний хамтын хичээл зүтгэл, Та бүхний итгэлцлийн үр дүн юм.

Эцэст нь, компанид итгэл хүлээлгэж, тасралтгүй дэмжлэг үзүүлдэг эрхэм хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон түншүүд Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөн энэхүү амжилтыг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан нийт хамт олондоо талархал илэрхийлье.

ХҮНДЭТГЭСЭН:




БААТАРСҮРЭНГИЙН ЭНХБОЛД




ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



[MSE:QRAY] ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ



[MSE:QRAY] ХУВЬЦААНЫ АРИЛЖАА /2025 ОН/

Дээд ханш **243.79** | Доод ханш **171.38** | Жигнэсэн дундаж ханш **204.90**

Өдрийн дундаж арилжаа
Хувьцааны тоо: **55.5 мян.ш** | Арилжааны дүн: **11.4 сая₮**

Жилийн нийт арилжаа
Хувьцааны тоо: **13.7 сая.ш** | Арилжааны дүн: **2.8 тэрбум₮**

Багцын арилжаа
Арилжааны тоо: **7 удаа** | Хувьцааны тоо: **102.3 сая.ш** | Арилжааны дүн: **25.5 тэрбум₮**

Book value **167.5** | EPS харьцаа **72.7** | P/BV харьцаа **1.2** | P/E харьцаа **2.8**

*2025 оны жигнэсэн дундаж ханшаар тооцсон

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт **4,482** хувьцаа эзэмшигчтэй байна.

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. QPAY- н эко систем
2. Бэлэн бус төлбөр тооцооны зах зээл эзлэлт
3. QPAY- н тоон үзүүлэлтүүд
4. Онцлох санхүүгийн үзүүлэлтүүд
5. Онцлох ажлууд
6. IPO хийх үеийн төсөөлөл ба гүйцэтгэл
7. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт
8. Нийгмийн хариуцлага



БАНК

ГОЛОМТ БАНК, КАПИТРОН БАНК, Mbank, ТӨРИЙН БАНК, БОГД БАНК, TDB, ХААН БАНК, tbank, ХАСВАНК, ҮЙНИГ ХААН БАНК, TransBank, АРИГ БАНК

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЭСХЭВЭР ГЭЛЭГ, МИА, ДАТАСАН, Datacenter, МОНГОЛ УЛСЫН ЭСХЭВЭР ГЭЛЭГ, e, АИГ, АИГ, АИГ, АИГ, MORE

FINTECH

TOKI, simple, ARD, pay, sendmn, SocialPay, SuperUp, monpay, Pay Jn, Storepay, MORE

ДААТГАЛ

НОМИН, МАРИЛ ДААТГАЛ, ТЭНГЭР ДААТГАЛ, ПРАКТИКАЛ, ХААН ДААТГАЛ, МОНГОЛ ДААТГАЛ, MWG ДААТГАЛ, БОДЬ ДААТГАЛ, ARD ДААТГАЛ, АМАР ДААТГАЛ, MUNKH ДААТГАЛ, MORE

VENDOR

coreMind, SMART LOGIC, Data Care, DATABANK, MORE

GLOBAL PAYMENT

VISA, WeChat Pay, mastercard, UnionPay, zero, GLN

КИНО ТЕАТР

CINEMA NEXT, Ceggenen, URGOO, ТЭНГИС, PRIME CINEMPLEX, HUMNU



СҮЛЖЭЭ ДЭЛГҮҮР

НОМИН, emart, Carrefour, SANSAR, GOOD PRICE, m-mart, ЦХАНБУРГЕДЕГ, NARAN SUPERMARKET, МИНИИ, Tout'en, EFES, MORE

ҮҮРЭН ХОЛБОО

STARLINK, LIME, mobicom, UNITEL, gmobile, SKYtel, TELECOM MONGOL, ONDO, MORE

E-COMMERCE

shoppy, UNEGUI.MN, emonos, a, banana, zahii, Z, Hi, cheapah, emall, Rio.mn, UBCAB

ELECTRONICS

next, PC mall, BSB Better Lifestyle, ARINA ELECTRONICS, CITY MALL, HOMELUX

IPTV

UNIVISION, voo home, GO, ORI, DDISH, LookTV, SKYmedia, media, MORE

ШАТАХУУН ТҮГЭЭХ

MT, ШУНХЛАЙ, ТЭС, СОГ МОНГОЛ ГРУПП, ПЕТРОВИС, ЖАСТ ОЙА, СУНЧУ ОЙН, MORE

TRANSPORT

aba, UBCAB, ECO BIKE, JET, tapatrip, Tino, MORE

RESTAURANT

THE BULL, NAMASTE RESTAURANT, CANTÉ, LOTTERIA, LookTV, SKYmedia, media, MORE

GLOBAL PAYMENT

VISA, WeChat Pay, mastercard, UnionPay, zero, GLN


AIR MARKET

HUMNU AIR, itrip, AIRMARKET, MIAT, ECHINA, MORE

282K+ MERCHANTS


БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улсын бэлэн бус төлбөр тооцооны зах зээл



2025 оны байдлаар Монгол улсын хэмжээнд 661.6 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 2.3 тэрбум гүйлгээ бэлэн бусаар хийгдсэн байна. Үүнээс картаар хийгдсэн гүйлгээ нь нийт гүйлгээний тооны 35.3 хувийг, харин хөдөлгөөнт банкны гүйлгээ 64.7 хувийг эзэлж байна.

Зах зээлд эзлэх хувь



QRau үйлчилгээгээр хийгдэж буй гүйлгээнүүд тогтмол өсч 2024 оны эцсээр бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн 8.5 хувийг эзэлж байсан бол 2025 оны байдлаар 11.0 хувьд хүрч зах зээлд эзлэх байр сууриа нэмсээр байна.



+2.8 САЯ
QPAУ ХЭРЭГЛЭГЧИД



21 АЙМАГ
QPAУ ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТЭРСЭН




+282 МЯНГА
МЕРЧАНТУУД




132.5 МЯНГА
QPAУ WALLET ХЭРЭГЛЭГЧИД

QPAУ- ГҮЙЛГЭЭНИЙ ТООН ҮЗҮҮЛЭЛТ /2021-2025/

ГҮЙЛГЭЭНИЙ ТОО /МЯНГАН ШИРХЭГ/



ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН /ТЭРБУМ.ТӨГ/



2025 ОНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

ӨДРИЙН ДУНДАЖ
ГҮЙЛГЭЭНИЙ ТОО

684.9 МЯНГАН
ШИРХЭГ

САРЫН ДУНДАЖ
ГҮЙЛГЭЭНИЙ ТОО

20.8 САЯ
ШИРХЭГ

ЖИЛИЙН НИЙТ
ГҮЙЛГЭЭНИЙ ТОО

249.8 САЯ
ШИРХЭГ

ӨДРИЙН ДУНДАЖ
ГҮЙЛГЭЭНИЙ ҮНИЙН ДҮН

44.6 ТЭРБУМ
ТӨГРӨГ

САРЫН ДУНДАЖ
ГҮЙЛГЭЭНИЙ ҮНИЙН ДҮН

1,358.4 ТЭРБУМ
ТӨГРӨГ

ЖИЛИЙН НИЙТ
ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН

16.1 ИХ НАЯД
ТӨГРӨГ

2025 ОН
НЭГЖ ГҮЙЛГЭЭНИЙ
ДУНДАЖ ҮНИЙН ДҮН

65,206₮

QPAУ-Н ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2025 оны онцлох санхүүгийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/



Санхүүгийн үзүүлэлт /тэрбум төгрөг/	2023	2024	2025	YoY
Орлогын тайлан				
Борлуулалтын орлого	13.24	26.23	38.13	45%
Борлуулалтын өртөг	6.04	12.05	19.98	66%
Нийт ашиг	7.2	14.18	18.15	28%
Цэвэр ашиг	5.7	10.03	13.44	34%
Баланс				
Нийт хөрөнгө	18.76	21.71	34.20	58%
Эргэлтийн хөрөнгө	17.87	18.73	30.44	63%
Нийт өр төлбөр	1.32	6.43	3.23	-50%
Өөрийн хөрөнгө	17.45	15.28	30.97	103%
Мөнгөн гүйлгээ				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3.91	8.80	10.28	17%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-0.38	-1.63	3.76	-330%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	8.61	-6.51	-4.62	-29%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12.15	0.65	9.45	1346%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1.85	14.00	14.65	5%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14.00	14.65	24.11	65%

2025 оны онцлох харьцаа үзүүлэлтүүд



Харьцаа үзүүлэлтүүд	2023	2024	2025
Ашигт ажиллагаа			
Нийт ашгийн маржин	54.4%	54.1%	47.6%
Үйл ажиллагааны ашгийн ахиуц	48.2%	49.7%	40.4%
Цэвэр ашгийн маржин	43.0%	38.2%	35.3%
Өөрийн хөрөнгийн өгөөж	48.2%	61.3%	43.4%
Нийт хөрөнгийн өгөөж	44.6%	49.5%	39.3%
Хөрвөх чадвар			
Эргэлтийн харьцаа	14	2.9	11.2
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	12.1	2.7	8.8
Төлбөрийн чадвар			
Өрийн харьцаа	7.0%	29.6%	9.4%
Өр ба эздийн өмчийн харьцаа	93.0%	70.4%	10.4%
Үнэлгээ			
BVPS	-	82.6	167.5
EPS	-	54.2	72.7
P/B	-	2.6	1.2
P/E	-	4	2.8



QFUND ТӨСӨЛ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ.

QR-ээр хийгдсэн гүйлгээ бүрээс сан бүрдүүлж, нийгэмд бодит үр нөлөөтэй санаачилгыг дэмжих зорилготой QFund төсөл амжилттай хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд:

- "Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төв"-ийн засварт хандив өгсөн;
- "Ой" хүүхдэд зориулсан сургалт, тоглолтыг дэмжсэн;
- "Лантуун дохио" ТББ-ын "Ид шидийн уут" аяныг дэмжсэн

ISO27001:2022 СТАНДАРТЫН БАТАЛГААЖИЛТЫГ ХАНГАВ

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2022 стандартын шаардлагыг ханган, Франц улсын AFNOR байгууллагаас албан ёсны сертификат гардан авсан. МАБМТ-ийн хэрэгжилтийг тогтмол ханган ажиллаж, дотоод хяналт, сайжруулалтыг хэрэгжүүлсэн.




БНСУ-ЫН GME КОМПАНИТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭГ БАЙГУУЛЛАА.

БНСУ-ын томоохон төлбөрийн аппликэйшн болох GME-ийн сая сая хэрэглэгчид Монгол Улсад QR-ээр үйлчилгээний QR кодыг уншуулан төлбөр тооцоогоо гүйцэтгэх боломж дахин нээгдэж байна. Ингэснээр QR-ээр сүлжээнд холбогдсон Солонгосын төлбөрийн аппликэйшний тоо нэгээр нэмэгдэж, хил дамнансан төлбөрийн экосистем улам өргөжиж байна.

ЦАХИМААР ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, QR-ИЙГ ХҮРГЭЛТЭЭР АВАХ БОЛОМЖТОЙ БОЛОВ

E-Geree тэй хамтран гэрээ байгуулах процессыг бүрэн цахимжуулж, зайнаас баталгаажуулах боломжийг нэвтрүүлэв. Ингэснээр иргэн мерчант цахимаар гэрээ байгуулж QR-ээр хэвлэмэл QR-ийг хүргэлтээр авах боломжтой болов.



ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР ШАЛГАРЛАА

Монгол Улсын эдийн засагт бодит хувь нэмэр оруулж, хариуцлагатай үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлсний үр дүнд 2025 онд "Инновэйшн Инвестмент" ХК болон түүний охин компани болох "ККТТ" ХХК нь жижиг болон дунд сегментийн 2024 оны Шилдэг татвар төлөгчөөр шалгарлаа.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭДЭЭ НОГДОЛ АШИГ ОЛГОВ

2025 оны цэвэр ашгаас 2026 оны 02 дугаар сарын 12-ны 01/01 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 50 төгрөг нийт 9.24 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ҮЦТХТ-өөр дамжуулан хуваарилахаар шийдвэрлэсэн.

МХБ-ИЙН ТОП 20 ИНДЕКСЭД НЭМЭГДЭЖ ОРЛОО

"Инновэйшн инвестмент" ХК-ийн QR-символтой үнэт цаас нь Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индексэд 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр нэмэгдэж орлоо.

WWW.I-INVESTMENT.MN ВЭБСАЙТ ШИНЭЧИЛЖ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ЗОРИУЛСАН ЦЭСТЭЙ БОЛЛОО

Инновэйшн Инвестмент ХК-ийн website-г шинэчилж хөрөнгө оруулагчдад зориулсан цэстэй боллоо.

2025 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД



ТЕХНИКИЙН ЭМЗЭГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭВ

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын SISA байгууллагатай хамтран мэдээллийн системийн техникийн эмзэг байдлын үнэлгээ (Vulnerability Assessment)-г хийж гүйцэтгэн, илэрсэн зөрчил, сул талыг үе шаттайгаар арилгасан.



RPA ТУСГААРЛАСАН ДЭД БҮТЦИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛСЭН

RPA буюу гүйлгээний тайлан, мэдээг бодит цагийн горимоор харах, автоматжуулах төслийн хүрээнд үндсэн өгөгдлийн сангийн гүйцэтгэлд нөлөөлөхгүй тусгаарласан дэд бүтцийн орчинг бүрдүүлсэн. Ингэснээр бизнесийн шийдвэр гаргалтанд тоон мэдээллийг ашиглан үнэн зөв, түргэн шуурхай ашиглах боломж бүрдсэн.



TELEPORT PAM СИСТЕМИЙГ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЭВ

QPay төлбөрийн системийн сервер болон өгөгдлийн сан руу давуу эрхтэй (privileged) хэрэглэгчийн хандалтад хяналт тавих, үйлдлийн лог бүртгэх, аудитын мөрдлөгийг хангах зорилгоор нээлттэй эхийн Teleport PAM (Privileged Access Management) системийг амжилттай нэвтрүүлж, үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн.



НӨӨЦ ДАТА ТӨВИЙН БАЙРШЛЫГ ӨӨРЧЛӨВ

Байгалийн гамшигт үзэгдлээс тодорхой түвшинд сэргийлэх үүднээс Нөөц дата төвийг Үндсэн дата төвөөс зайны хувьд холдуулах арга хэмжээг хэрэгжүүлэв. Тухайн суурь дэд бүтцийг шинээр зохион байгуулж өгөгдлийн сангуудыг бодит цагийн горимоор хуулбарлан хадгалж байна.



HPE DHCI ШИНЭ ДЭД БҮТЭЦ

2024 оны 9 сард худалдан авсан HPE dHCI суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжид Qray төлбөрийн системийн үндсэн орчныг бүрэн шилжүүлж дуусгав. Үндсэн орчныг тасалдал, зогсолт хамгийн багатайгаар шилжүүлсэн бөгөөд шинэ дэд бүтэц рүү шилжүүлснээр хурд гүйцэтгэл сайжирч, нөөц ашиглалт нэмэгдэн, системийн тогтвортой ажиллагаа хангагдав.



TICKET СИСТЕМИЙГ НИЙТ ХАРИЛЦАГЧДАД НЭВТРҮҮЛЛЭЭ.

Компанийн гадаад болон дотоод үйл ажиллагааны үр ашиг, хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Тикет системийн хөгжүүлэлтийг бүрэн дуусгаж, бодит орчинд албан ёсоор нэвтрүүлээ.



IBAN ДАНСНЫ ДУГААРЛАЛТРУУ ШИЛЖИВ

Монгол банкнаас гаргасан журмын дагуу арилжааны банкууд нь дансны дугаарлалтыг IBAN стандарт руу шилжүүлсэн тул түүнд нийцүүлэн бүх төрлийн гүйлгээг IBAN дугаарлалтаар хийх боломжийг бүрдүүлэв.




МОНИТОРИНГ, ALERTING СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЖ НЭВТРҮҮЛСЭН

Дэд бүтцийн сервер, системийн түвшинд гарч болзошгүй алдаа доголдлыг шуурхай илрүүлэх мониторинг, alerting системийг хөгжүүлж нэвтрүүлсэн. Анхааруулгыг гар утасны дуудлага, и-мэйл, мессежээр хүлээн авах боломж бүрдүүлснээр асуудлыг богино хугацаанд илрүүлж, шийдвэрлэх нөхцөл бүрдсэн.


ИРО ХИЙХ ҮЕИЙН ТӨСӨӨЛӨЛ БА ГҮЙЦЭТГЭЛ /2023-2025/

**БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
(ТЭРБУМ ТӨГРӨГ)**




2025 онд борлуулалтын орлого 38.1 тэрбум төгрөгт хүрснээр IPO хийхүеийн төсөөллийг 162%-иар биелүүллээ.

**ЦЭВЭР АШИГ
(ТЭРБУМ ТӨГРӨГ)**




2025 онд цэвэр ашиг 13.4 тэрбум төгрөгт хүрснээр IPO хийх үеийн төсөөллийг 127%-иар биелүүллээ.

**НИЙТ ХӨРӨНГӨ
(ТЭРБУМ ТӨГРӨГ)**



2025 онд нийт хөрөнгө 34.2 тэрбум төгрөгт хүрснээр IPO хийх үеийн төсөөллийг 116%-иар биелүүллээ.

**ӨӨРИЙН ХӨРӨНГӨ
(ТЭРБУМ ТӨГРӨГ)**



2025 онд өөрийн хөрөнгө 30.9 тэрбум төгрөгт хүрсэн нь IPO хийх үеийн төсөөллийг 108%-иар биелүүлсэн байна.

*ИРО ХИЙХ ҮЕИЙН ТӨСӨӨЛӨЛ

ГҮЙЦЭТГЭЛ

БИЕЛЭЛТИЙН ХУВЬ

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ



Иновэйшн Инвестмент ХК нь хувьцаагаа олон нийтэд санал болгож 2023.12.04-ний өдрөөс 2023.12.08-ны өдрийн хооронд Монголын хөрөнгийн бирж дээр анхдагч зах зээлийн захиалга авч **8.3 тэрбум** төгрөгийг татан төвлөрүүлсэн.


№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Зарцуулахаар төлөвлөсөн 2023-2026 он		Зарцуулалт 2025 он	
		/сая₮/	/Хувиар/	/сая₮/	/Хувиар/
1	Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт	1,871.99	22.5%	139.94	1.68%
2	Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа	2,495.99	30.0%	0	0.00%
3	Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа	1,247.99	15.0%	1,190.38	14.31%
4	"ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр	2,080.00	25.0%	2,080.00	25.00%
5	Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах	623.99	7.5%	0	0.00%
	Нийт	8,319.96	100%	3,410.32	41.0%

- 2023 оны 12 дугаар сард нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн **25%** буюу "ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр болох **2,080,003,050** төгрөгийг зориулалтын дагуу ККТТ ХХК руу шилжүүлсэн.
- Мөн 2024 оны 2 дугаар хагас жилээс эхлүүлсэн QPaу үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой компани ажлын хүрээнд нийт 139,938,166 төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн "Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үйл ажиллагааны тэлэлт" хэсгээс зориулалтын дагуу зарцуулаад байна.
- 2025 онд QPaу төлбөрийн системийн суурь дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд Суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжийг шинээр худалдаж авах болон одоогийн сервер, тоног төхөөрөмжийг өргөтгөх чиглэлээр нийт **1,190,378,556** төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалтыг хийгээд байгаа бөгөөд үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15% буюу "Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа"-нд зориулагдах **1,247,994,608** төгрөгөөс зарцуулсан.
- Бид одоогоор нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн **41.0%**-ийг зориулалтын дагуу зарцуулаад байгаа ба үлдсэн хөрөнгийг зориулалтын дагуу 2026 онд зарцуулахаар төлөвлөж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



2025 онд Инновэйшн Инвестмент ХК нь олон улсын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх замаар нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлэхэд чиглэсэн бодлого, санаачилгуудыг хэрэгжүүллээ. Үүнд:




QFUND ТӨСӨЛ НЬ QRAY-ЭЭР ХИЙГДСЭН ГҮЙЛГЭЭ БҮРЭЭС САН БҮРДҮҮЛЖ, НИЙГЭМД БОДИТ ҮР НӨЛӨӨТЭЙ САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ ЗОРИЛГОТОЙ. ТӨСЛИЙН ХҮРЭЭНД

- Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төв"-ийн хүүхдийн мэдрэлийн мэс заслын тасгийг засварлаж, хөгжлийн онцлогтой хүүхдүүдэд зориулсан эмчилгээ, сэргээн засах үйлчилгээг сайжруулсан;
- "Ой" өвийн өртөө санаачилгын санхүүжилтээр хүүхдэд зориулсан сургалт, тоглолт зохион байгуулж, Монголын өв соёл, түүхийг түгээн дэлгэрүүлсэн;
- "Лантуун дохио" ТББ-ын "Ид шидийн уут" аяныг дэмжиж, хүүхдэд бэлэг түгээх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хувь нэмэр оруулсан.



ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ НЬ

"Инновэйшн Инвестмент" ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд чанартай боловсролыг дэмжих зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуульд нийт 50 ширхэг зөөврийн компьютер хүлээлгэн өгсөн ба тус хандив нь багш нарын заах арга барилын хүртээмжийг нэмэгдүүлж, хичээл сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг ашиглах чухал ач холбогдолтой юм. Цахим сургалтын хэрэглээг өргөжүүлснээр багш нарын хичээл бэлтгэх болон үнэлгээ хийх үйл ажиллагааг оновчтой болгох, багшийн ажлын ачааллыг бууруулахад бодит дэмжлэг үзүүлэх чухал нөлөөтэй.



ЗАЛУУС БА СПОРТЫГ ДЭМЖИХ САНААЧИЛГА

Залуусын дунд эерэг нөлөөлөл бий болгох, спортын хөгжлийг дэмжих мөн байгууллагын брэндийн танигдах байдлыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Darkhan Moguls волейболын багтай хамтран ажиллах, дэмжих гэрээг байгуулсан.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт
2. Санхүү байдлын тайлан
3. Орлого үр дүнгийн тайлан
4. Өмчийн өөрчлөлтийн тайлан
5. Мөнгөн гүйлгээний тайлан

2025 ОНЫ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ



Мүүрь Аудит ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо Олимпийн гудамж 7/3,
Центрум төв 7 давхар, 701 тоот
Утас : +976 7015 0003
Факс: +976 7015 0003
И-мэйл: info@moore-mongolia.mn
www.moore-mongolia.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид, Инновэйшн Инвестмент ХК болон түүний охин компаниуд (хамтад нь Групп гэх)-ын 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Группийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн дүрэм (Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаасан)-д заасан олон нийтийн ашиг сонирхлын байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагууд болон Монгол улсын Аудитын тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагууд болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн дагуу тавигддаг бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжийн хүрээнд тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг бүхэлд нь авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.

Аудитын гол асуудал

Тайлант жил 38,125,353 (2024; 26,231,629) мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. (Тод.б)

Энэ нь QR код ашиглан хийсэн ажил гүйлгээнд ногдуулсан шимтгэлийн хураамж авах үндсэн үйл ажиллагааны орлого юм.

Бид аудитаар аудитын гол асуудлыг хэрхэн авч үзсэн

Группийн хувьд харилцагч ба мерчантууд нь QR кодыг хэр зэрэг идэвхтэй ашиглан, цахим шилжүүлэг хийхээс үйлчилгээний орлого хамаарах бөгөөд маш их хэмжээний ажил гүйлгээний дүнгээс шимтгэлийн орлого ба шимтгэлийн буцаалтын зардлыг тооцоолдог. Орлого нь тухайн агшинд хэрэгждэг бөгөөд тооцоолол хийх датаны иж бүрэн байдал, тооцооллын найдвартай, үнэн зөв байдал чухал учир бид ихээхэн анхаарал хандуулсан.

Бид дараах горимуудыг гүйцэтгэсэн:

- Орлого хүлээн зөвшөөрөлтийн бодлого ба тууштай байдал, аргачлал өгөгдлийг зөв хэрэглэж байгаа эсэхийг үнэлсэн.
- Датаны иж бүрэн байдалд хяналтын тест хэрэгжүүлсэн.
- Сонгосон хугацааны шимтгэлийн тооцооллын үнэн зөвийг давтан тооцоолж шалгасан.
- Билл нөхцөлтэй харилцагчдын тооцоо иж бүрэн хийгдсэн эсэхийг түүвэрлэн шалгасан.
- QR код үүсгэх системд харилцагчтай байгуулсан гэрээний нөхцөл шаардлагыг зөв оруулсан эсэхийг түүврийн аргаар шалгасан.
- Мэдээллийн аюулгүй байдал, зөвшөөрлийн функцууд зохистой ажиллаж байгаа эсэхийг үнэлсэн.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг буруу илэрхийлэлгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Группийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, мөн Группийн үйл ажиллагааг зогсоох буюу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний аудитын зорилго нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах, мөн бидний дүгнэлтийг багтаасан аудитын тайлан гаргах юм. Үндэслэлтэй баталгаа гэдэг нь өндөр түвшний баталгаа боловч Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл оршин буй тохиолдолд үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба тэдгээр нь дангаараа эсвэл

2025 ОНЫ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ /ҮРГЭЛЖЛЭЛ/

нийлээд тэдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрүүдэд нөлөөлөхөөр байвал тэдгээрийг материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг болгон бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж, мөн аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандана. Бид түүнчлэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг үнэлэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу үзүүлэх аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэнэ, мөн өөрсдийнхөө дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай зохистой нотолгоо олж авна. Залилан нь үгсэн хуйвалдах, бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, гуйвуулах эсвэл дотоод хяналтыг үл хэрэгсэх зэргийг багтаасан байж болох учраас залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус, тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн Группийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадварт томоохон эргэлзээ үүсгэхүйц үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Группийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлнэ, мөн нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар үндсэн гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг тусгасан эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад дүгнэлт илэрхийлэхийн тулд Группийн доторх аж ахуйн нэгжүүд эсвэл бизнесийн үйл ажиллагаануудын санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай зохистой аудитын нотолгоо олж авдаг. Бид Группийн аудитын ажлыг удирдан чиглүүлж, хянаж, гүйцэтгэхэд хариуцлага хүлээнэ. Бид өөрсдийн аудитын дүгнэлтдээ дангаар хариуцлага хүлээнэ.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа томоохон сул талыг багтаагаад илрүүлсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажилласан талаарх мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид

хараат бус байдлын хүрээнд бүх харилцаа холбоо болон бодолцож үзвэл зохих бусад асуудлуудаар, хамааралтай бол, хараат бус байдалд учирсан сөрөг нөлөөнүүдийг арилгахын тулд авсан арга хэмжээнүүд, хэрэглэсэн хамгаалалтуудын талаар тэдгээр хүмүүстэй харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн үлэмж нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар тухайн асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд, аудиторын тайландаа тухайн асуудлаар харилцах нь уг харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж бид үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр гол асуудлыг аудиторын тайландаа тусгадаг.


Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт 2025 оны 12 сарын 31-нээр тасалбар болсон Группийн жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудитын тайлан үүнд хамаарахгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд илэрхийлсэн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй буюу бид үүнтэй холбоотой ямар нэгэн баталгаажуулалт хийгээгүй болно.

Бидний гүйцэтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг уншиж танилцан, бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан аудиторын мэдлэгээс материаллаг зөрүүтэй эсэхийг тодорхойлох үүрэгтэй.

Хэрэв бусад мэдээлэл нь материаллаг зөрүүтэй бол бид энэ тухай тайлагнах үүрэгтэй. Группийн 2025 оны жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлангаас хойш бидэнд танилцуулагдахаар хүлээгдэж байна. Хэрэв жилийн тайлантай танилцах үед бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл холбогдох арга хэмжээг дурдан бид засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх болно.



Хаяг: Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, Центрум төв, 7 давхар, 701 тоот.

Утас: 976-7015 0003, **И-мэйл:** info@moore-mongolia.mn

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (АУДИТЛАГДСАН)

МЯНГАН ТӨГРӨГӨӨР

Үзүүлэлт	2025	2024
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	24,107,941	14,653,598
Худалдааны болон бусад авлага	3,101,491	3,010,240
Орлогын албан татварын авлага	262,979	-
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	133,652	114,825
Бусад санхүүгийн хөрөнгө	2,826,470	944,832
Бараа материал	3,793	2,737
Эргэлтийн хөрөнгийн дүн	30,436,326	18,726,232
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,558,625	1,229,171
Биет бус хөрөнгө	404,630	505,973
Ашиглах эрхтэй хөрөнгө	825,614	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	669,400	1,250,000
Хойшлогдсон татварын хөрөнгө	304,969	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,763,238	2,985,144
НИЙТ ХӨРӨНГӨ	34,199,564	21,711,376
ӨР ТӨЛБӨР		
Эргэлтийн өр төлбөр		
Худалдааны болон бусад өр төлбөр	2,344,631	2,269,607
Орлогын албан татварын өр төлбөр	-	392,494
Түрээсийн өр төлбөр (эргэлтийн)	368,112	-
Ногдол ашигт өглөг	50	3,697,783
Гэрээний өр төлбөр	13,007	-
Эргэлтийн өр төлбөр	2,725,800	6,359,884
Эргэлтийн бус өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр	-	71,576
Түрээсийн өр төлбөр	504,977	-
Эргэлтийн бус өр төлбөр	504,977	71,576
Нийт өр төлбөр	3,230,777	6,431,460
Цэвэр хөрөнгө	30,968,787	15,279,916
ӨМЧ		
Хувьцаат капитал	4,622,229	4,284,927
Хуримтлагдсан ашиг	21,149,518	7,440,476
Нэмж төлөгдсөн капитал	5,197,040	3,554,513
НИЙТ ӨМЧ	30,968,787	15,279,916

НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН (АУДИТЛАГДСАН)

МЯНГАН ТӨГРӨГӨӨР

Үзүүлэлт	2025	2024
Борлуулалтын орлого (цэвэр)	38,125,353	26,231,629
Борлуулалтын өртөг	(19,976,136)	(12,051,045)
Нийт ашиг	18,149,217	14,180,584
Бусад орлого	57,328	69,105
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,514,222)	(1,941,550)
Борлуулалт, маркетингийн зардал	(1,465,571)	(805,563)
Бусад зардал	(436,483)	(48,929)
Үйл ажиллагааны ашиг	12,790,269	11,453,647
Санхүүгийн орлого	2,019,583	1,608,190
Санхүүгийн зардал	(141,249)	(1,703)
Цэвэр санхүүгийн орлого	1,878,334	1,606,487
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	39,866	(13,528)
Хөрөнгө оруулалт борлуулсны олз	685,663	-
Татварын өмнөх ашиг	15,394,132	13,046,606
Орлогын татварын зардал	(1,954,931)	(3,020,452)
Тайлант жилийн цэвэр ашиг	13,439,201	10,026,154
Үндсэн нэгж хувьцаанд ногдох ашиг, төгрөг	72.69	54.32

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (АУДИТЛАГДСАН)

МЯНГАН ТӨГРӨГӨӨР

Үзүүлэлт	2025	2024
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлого	42,212,344	28,926,589
Үйлчилгээ үзүүлсний орлого	41,722,395	27,482,043
Бусад орлого	569	233
Бусад мөнгөн орлого	489,380	1,444,313
Мөнгөн зарлага	(31,934,027)	(20,131,650)
Ажиллагсад төлсөн	(2,737,435)	(1,558,490)
Нийгмийн даатгалд төлсөн	(758,665)	(414,988)
Татвар төлсөн	(7,852,369)	(5,300,248)
Бусад мөнгөн зарлага	(20,585,558)	(12,857,924)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	10,278,317	8,794,939
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлого	7,493,272	1,975,402
Хөрөнгө борлуулснаас хүлээн авсан мөнгө	590	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас хүлээн авсан мөнгө	3,483,658	414,630
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгааны төлөлт	1,975,061	267,021
Хүлээн авсан хүү	1,979,501	1,228,103
Хүлээн авсан ногдол ашиг	54,462	65,648
Мөнгөн зарлага	(3,736,944)	(3,609,438)
Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	(1,169,400)	(2,215,903)
Биет ба биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн	(606,382)	(1,387,015)
Бусдад олгосон зээл	(1,961,162)	(6,520)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,756,328	1,634,036
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлого	-	103,027
Гаргасан хувьцаа	-	103,027
Мөнгөн зарлага	(4,620,082)	(6,613,111)
Төлсөн ногдол ашиг	(3,183,518)	(6,575,070)
Хадгаламж тусгаарласан	(981,638)	-
Төлсөн түрээсийн өр	(454,926)	(38,041)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(4,620,082)	(6,510,084)
Мөнгөн хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлийн нөлөө	39,780	2,959
Тайлант жилийн бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9,454,343	653,778
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,653,598	13,999,820
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,107,941	14,653,598

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (АУДИТЛАГДСАН)

МЯНГАН ТӨГРӨГӨӨР

Үзүүлэлт	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт
2024.01.01-ний үлдэгдэл	4,622,229	4,653,188	8,368,940	17,644,357
Өмчид гарсан өөрчлөлт	(337,302)	(1,098,675)	440,101	(995,876)
Зарласан ногдол ашиг	-	-	(11,394,719)	(11,394,719)
Тайлант жилийн ашиг	-	-	10,026,154	10,026,154
2024.12.31-ний үлдэгдэл	4,284,927	3,554,513	7,440,476	15,279,916
Өмчид гарсан өөрчлөлт	337,302	1,642,527	269,841	2,249,670
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант жилийн ашиг	-	-	13,439,201	13,439,201
2025.12.31-ний үлдэгдэл	4,622,229	5,197,040	21,149,518	30,968,787

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

1. ТУЗ-ийн гишүүд
2. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан
3. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай
4. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт
5. Ногдол ашгийн мэдээлэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



А.БАТТАМИР

ТУЗ-ИЙН ДАРГА

Ай Си Ти Групп ХК-ийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга, Мэдээлэл технологийн салбарт 19 жил ажилласан туршлагатай



Б.НАНДИН-ЭРДЭНЭ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Санхүү эдийн засгийн их сургуулийн ахлах багш, Боловсролын салбарт 23 жил ажилласан туршлагатай



Т.ДАШЦЭРЭН

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Үндэсний хөрөнгө оруулалтын банкны МТГ-н захирал, Мэдээлэл технологийн салбарт 13 жил ажилласан туршлагатай



Ш.УЯНГА

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Лидер акаунт аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Татвар, санхүүгийн салбарт 21 жил ажилласан туршлагатай



Б.АНХБОЛД

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Айкор Партнерс ХХК-ийн ТУЗ-ийн дарга, CEO, Мэдээлэл технологийн салбарт 13 жил ажилласан туршлагатай



Г.ХАТАНБОЛД

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Ай Си Ти Групп ХК-ийн Гүйцэтгэх захирал Хөрөнгө оруулалт, менежмент, мэдээлэл технологийн салбарт 21 жил ажилласан туршлагатай



Б.ЧУЛУУНСҮХ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Инновэйшн инвестмент ХК-ийн хамтран үүсгэн байгуулагч, Мэдээлэл технологийн салбарт 17 жил ажилласан туршлагатай



У.НАРАНБААТАР

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Могоул ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Банк, санхүү, мэдээлэл технологийн салбарт 21 жил ажилласан туршлагатай



У.МӨНХЗУЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Эн Си Ди Групп ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал, Үл хөдлөх барилга угсралтын салбарт 9 жил ажилласан туршлагатай



О.МАРАЛМАА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Компанийн засаглал, үйл ажиллагааны чиглэлээр 10 жил ажилласан ажлын туршлагатай

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 77.58% хувийн ирцтэй амжилттай зохион байгуулагдсан бөгөөд дараах асуудлуудыг санал хураан шийдвэрлэсэн. Үүнд:

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99 хувь зөвшөөрсөн.
- ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах, нөхөн олгох тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 95.37 хувь зөвшөөрсөн.
- Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99 хувь зөвшөөрсөн.

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байдаг.

ТУЗ-ИЙН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

ТУЗ нь 2025 онд биечлэн, цахимаар, биечлэн болон цахим хосолсон, эчнээ санал хэлбэрээр нийт 22 удаа, 77.8% ба түүнээс дээш хувийн ирцтэй хуралдаж, 76 тогтоол шийдвэр гаргасан.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

ТУЗ-ийн дэргэдэх хороод	Худалдсан тоо
Аудитын хороо	1 удаа
Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо	6 удаа
Эрсдэлийн удирдлагын хороо	1 удаа
Стратеги хөгжлийн хороо	1 удаа

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ийн дэргэд 4 хороод ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэдэх хороод нийт 9 удаа хуралдаж хороодын чиг үүргийн хүрээнд хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан.

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

Компани нь голлох удирдлагуудад олгох цалин хөлс, урамшуулал, тэтгэмжийн асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох дүрэм журам, Инновэйшн Инвестмент ХК-ийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 14 дүгээр бүлэг, Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний хүрээнд тооцон олгож байна.

ТУЗ-ИЙН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн цалин урамшуулал	
Ердийн гишүүн-6	Жилийн нийт цалин: 247.6 Сая төгрөг
Хараат бус гишүүн -3	
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Тайлант онд голлох удирдлагын цалин хөлс, урамшууллын зардал 1,127.6 сая төгрөг байна.

ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ТУХАЙ



СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ТУХАЙ

- 2025/06/06-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №06/49 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигч Могоул ХХК-ийн охин компани болох Ай Ти Зон ХХК-иас дэд бүтцийн тоног төхөөрөмж 129,103,900 /нэг зуун хорин есөн сая нэг зуун гурван мянга есөн зуу/ төгрөгөөр худалдаж авах шийдвэр гаргасан.
- 2025/11/13-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №11/71 тоот тогтоолоор "Инновэйшн инвестмент" ХК-ийн охин компани болох "ККТТ" ХХК тай 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 100,000,000 /нэг зуун сая/ төгрөг татах "Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсан.
- 2025/11/13-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №11/72 тоот тогтоолоор Ай Ти Зон ХХК-иас "Инновэйшн инвестмент" ХК-ийн охин компани болох "ККТТ" ХХК-д сервер болон дагалдах тоног төхөөрөмж 894,194,726 /найман зуун ерөн дөрвөн сая нэг зуун ерөн дөрвөн мянга долоон зуун хорин зургаа/ төгрөгөөр худалдаж авах шийдвэр гаргасан.
- 2025/11/13-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №11/73 тоот тогтоолоор "Инновэйшн инвестмент" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Батзоригийн Чулуунсүхийг компанид 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2027 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 2 жилийн хугацаатай зөвлөхөөр ажиллуулах шийдвэр гаргасан.
- 2025/11/13-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №11/75 тоот тогтоолоор "Инновэйшн инвестмент" ХК-ийн охин компани болох "Дижитал Мерчант Сервисэс" ХХК тай 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 20,000,000 /хорин сая/ төгрөг татах "Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсан.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН 2025 ОНЫ "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	11	91.7%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	8	80.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	6	100.0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	6	100.0%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	8	100.0%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5	5	83.3%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	8	100.0%
8	Компанийн соёл	6	6	6	100.0%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	10	100.0%
Нэгдсэн дүн		72	69	68	94.4%

Санхүүгийн зохицуулах хорооны "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн хагас жилийн хянан баталгаажилтаар "Инновэйшн инвестмент" ХК нь 94.4% хувийн үнэлгээ авсан байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Энэхүү үнэлгээний зорилго нь "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухай байгууллагын "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

1. Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
2. 70–90 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
3. 50–60 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ



2024 ОНЫ ЦЭВЭР АШГААС 2025 ОНД ТАРААСАН НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 05/30 дугаар тогтоолоор 2024 оны сүүлийн хагас жилийн татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 20 төгрөг, нийт 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэж 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-аар дамжуулан олгосон.
- Компани нь 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас мөн нэгж хувьцаанд 20 төгрөг, нийт 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилсан билээ.

2025 ОНЫ ЦЭВЭР АШГААС 2026 ОНД ОЛГОХООР ЗАРЛАСАН НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/01 тоот тогтоолоор 2025 оны жилийн эцсийн татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 50 төгрөг, нийт 9.24 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэлэсэн.
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр нь 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр бөгөөд ногдол ашгийг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-аар дамжуулан олгоно.

2024 ОНЫ ЦЭВЭР АШГААС ХУВААРИЛСАН НОГДОЛ АШИГ

НЭГЖ ХУВЬЦААНД ОЛГОСОН НОГДОЛ АШИГ

НИЙТ ОЛГОСОН НОГДОЛ АШИГ

40.0
ТӨГРӨГ

7.4
ТЭРБУМ ТӨГРӨГ

НОГДОЛ АШГИЙН ӨГӨӨЖ:

18.0%

/2024 ОНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ ХАНШААР ТООЦСОН/

ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ:

10.0
ТЭРБУМ ТӨГРӨГ

АШГААС НОГДОЛ АШИГ ОЛГОСОН ХУВЬ:

73.8%

2025 ОНЫ ЦЭВЭР АШГААС ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр:

2026/04/10-ны өдөр

Нэгж хувьцаанд олгох ногдол ашиг:

50.0
ТӨГРӨГ

Нийт олгох ногдол ашиг:

9.24
ТЭРБУМ ТӨГРӨГ

НОГДОЛ АШГИЙН ӨГӨӨЖ:

19.0%

/2026/02/12-НИЙ ӨДРИЙН ХАНШААР ТООЦСОН/

ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ:

13.4
ТЭРБУМ ТӨГРӨГ

АШГААС НОГДОЛ АШИГ ОЛГОСОН ХУВЬ:

68.8%

2026/04/30-ны өдрийн дотор ногдол ашгийг ҮЦТХТ-өөр дамжуулантараана.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ



2024 ОНЫ ЦЭВЭР АШГААС 2025 ОНД ТАРААСАН НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН


**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ**
Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо, Самбуугийн гудамж 16/1
Утас: 70120460
И-мэйл: info@mcsd.mn Вэб хуудас: www.mcsd.mn

2025.04.31 № 01/501
танай _____-ны № _____-т

"ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХК-Д

Танай байгууллагатай 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан ногдол ашиг зуучлуулан тараах 03/12 тоот гэрээний дагуу нийт 1,852 хувьцаа эзэмшигчдийн дансанд 184,889,160 ширхэг хувьцаанд ногдох 3,439,865,262.00 /Гурван тэрбум дөрвөн зуун гучин есөн сая найман зуун жаран таван мянга хоёр зуун жаран хоёр төгрөг/-ийг 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр байршуулсан болно.

Хувийг: Санхүүгийн Зохицуулах Хороонд

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  М.ЭНХСАЙХАН



НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ


**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Дугаар 01/01 Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, "Иновэйшн инвестмент" ХК (цаашид "Компани" гэх)-ийн Дүрмийн 23 дугаар зүйл, Компанийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.8.7 дахь заалт болон "Ногдол ашгийн бодлого"-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Компанийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нийт эргэлтэнд гарсан 184,889,160 (нэг зуун наян дөрвөн сая найман зуун наян есөн мянга нэг зуун жаран) ширхэг энгийн хувьцаанд нийт 9,244,458,000.00 (есөн тэрбум хоёр зуун дөчин дөрвөн сая дөрвөн зуун тавин найман мянган) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
- Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 50 (тавин) төгрөгөөр тогтоосугай.
- Ногдол ашиг авах эрхтэй Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
- Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар, хуулийн этгээдийн хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай.
- Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгох шийдвэрийг хүргэх болон ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулж энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б. Энхболд/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  А.БАТТАМИР



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх

Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ



Иновэйшн Инвестмент" ХК-ийн Төлөөлөн
удирдах зөвлөлийн хурлын 2026 оны 03
дугаар сарын 20-ны өдрийн 26/04 тоот
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлав



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 26/04

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дүгээр заалт,
Компанийн дүрмийн 9.6.16 дугаар заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Иновэйшн Инвестмент ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг 1 дүгээр хавсралтаар гаргасугай.
- Гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Энхболд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР

КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь Компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд компанийн зүгээс тавих хяналтын үйл ажиллагаа болон компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дахин хянан нягталж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудиторуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

Иновэйшн Инвестмент ХК-ийн Аудитын хороо нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Аудитын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Уянга

Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Дашцэрэн, ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Хатанболд

Иновэйшн Инвестмент хк-ийн туз-өөс 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэхээр Мүүрь Аудит ххк-г сонгож, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тус компаниар хөндлөнгийн аудитыг хийлгүүлсэн бөгөөд санхүү бүртгэл, санхүүгийн тайлагналын хувьд СТОУС-д нийцсэн, ямар нэг зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Энэ онд тус хороо нь компанийн санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулах үндсэн чиг үүргийнхээ дагуу улирал бүрийн санхүүгийн тайлантай танилцаж үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэн ажиллалаа. Аудитын хорооны хурлаар тус компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт хийхдээ хөндлөнгийн аудит хийсэн байгууллагын дүгнэлт, компанийн Санхүү удирдлагын газраас гаргуулсан мэдээ, мэдээллийг үндэслэл болгов.

Дүгнэх нь: Иновэйшн Инвестмент ХК нь үндсэн бизнесийн хувьд өөрийн охин компаниар дамжуулан бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд QRu үйлчилгээгээр хэрэглэгч, байгууллагуудад технологид суурилсан төлбөр тооцооны шийдлийг санал болгон ажиллаж байна. Тус системийн онцлог нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгодог давуу талтай билээ. 2025 онд Компанийн стратеги бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд амжилттай ажилласан байна.

2025 онд QRu мерчантуудад илүү анхаарал хандуулж, QRu-ээр төлбөр хүлээн авах идэвхийг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх чиглэлээр зорилт тавьж ажилласан мөн цаашид тогтвортой өсөлтийг хангах үүднээс мерчант болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зах зээлд өрсөлдөхүйц шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийн суурийг амжилттай тавьсны үр дүнд 2025 онд QRu үйлчилгээгээр нийт 250.0 сая ширхэг гүйлгээ дамжсан бөгөөд энэ нь өмнөх оныхоос 42% -иар өссөн бол гүйлгээний үнийн дүнгийн хувьд өмнөх онтой харьцуулахад 54%-иар нэмэгдэж 16.3 их наяд төгрөгт хүрсэн байна.

Иновэйшн Инвестмент ХК нь нээлттэй хувьцаат компани болсоноос хойш Монголын төлбөр тооцооны зах зээлд өөрсдийн байр сууриа бэхжүүлж, өрсөлдөхүйц бүтээгдэхүүнүүдийг санал болгон амжилттай ажиллаж байна.

Үүний үр дүнд 2025 онд борлуулалтаа нэмэгдүүлэн 13.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Мөн 2024 оны жилийн цэвэр ашгаас нийт 7.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилж байсан бол 2025 оны жилийн цэвэр ашгаас 9.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэснээр өөрийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өгөөжийг өсгөн ажилласан байна.

Иновэйшн Инвестмент ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ болон өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тайлагнасан болохыг танилцуулж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх

Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР

ДУГААР 01

УЛААНБААТАР ХОТ

КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт "ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" хк-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх хэсэг 2026 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн тогтоох нь:

1. "ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" хк-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

А.БАТТАМИР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ



"Инновэйшн Инвестмент" ХК-ийн
2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
01-р тогтоолын 1-р хавсралт

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь Компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд компанийн зүгээс тавих хяналтын үйл ажиллагаа болон компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дахин хянан нягталж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудитуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

Инновэйшн Инвестмент хк-ийн туз-өөс 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэхээр Мүүрь Аудит ххк-г сонгож, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тус компаниар хөндлөнгийн аудитыг хийлгүүлсэн бөгөөд санхүү бүртгэл, санхүүгийн тайлагналын хувьд СТОУС-д нийцсэн, ямар нэг зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Энэ онд тус хороо нь компанийн санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулах үндсэн чиг үүргийнхээ дагуу улирал бүрийн санхүүгийн тайлантай танилцаж үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэн ажиллалаа. Аудитын хорооны хурлаар тус компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт хийхдээ хөндлөнгийн аудит хийсэн байгууллагын дүгнэлт, компанийн Санхүү удирдлагын газраас гаргуулсан мэдээ, мэдээллийг үндэслэл болгов.

Дүгнэх нь: Инновэйшн Инвестмент ХК нь үндсэн бизнесийн хувьд өөрийн охин компаниар дамжуулан бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд QRau үйлчилгээгээр хэрэглэгч, байгууллагуудад технологид суурилсан төлбөр тооцооны шийдлийг санал болгон ажиллаж байна. Тус системийн онцлог нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгодог давуу талтай билээ. 2025 онд Компанийн стратеги бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд амжилттай ажилласан байна.

2025 онд QRau мерчантуудад илүү анхаарал хандуулж, QRau-ээр төлбөр хүлээн авах идэвхийг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх чиглэлээр зорилт тавьж ажилласан мөн цаашид тогтвортой өсөлтийг хангах үүднээс мерчант болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зах зээлд өрсөлдөхүйц шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийн суурийг амжилттай тавьсны үр дүнд 2025 онд QRau үйлчилгээгээр нийт 250.0 сая ширхэг гүйлгээ дамжсан бөгөөд энэ нь өмнөх оныхоос 42% -иар өссөн бол гүйлгээний үнийн дүнгийн хувьд өмнөх онтой харьцуулахад 54%-иар нэмэгдэж 16.3 их наяд төгрөгт хүрсэн байна.

Инновэйшн Инвестмент ХК нь нээлттэй хувьцаат компани болсоноос хойш Монголын төлбөр тооцооны зах зээлд өөрсдийн байр сууриа бэхжүүлж, өрсөлдөхүйц бүтээгдэхүүнүүдийг санал болгон амжилттай ажиллаж байна.

Үүний үр дүнд 2025 онд борлуулалтаа нэмэгдүүлэн 13.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Мөн 2024 оны жилийн цэвэр ашгаас нийт 7.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилж байсан бол 2025 оны жилийн цэвэр ашгаас 9.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэснээр өөрийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өгөөжийг өсгөн ажилласан байна.

Инновэйшн Инвестмент ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ болон өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тайлагнасан болохыг танилцуулж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК

ХОЛБОО БАРИХ:

 WWW.I-INVESTMENT.MN

 (+976) 7610-2211

 INFO@QPAY.MN

 МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 15-Р ХОРОО,
ГАНДИГИЙН ГУДАМЖ, НМ TOWER ОФФИС, 8 ДАВХАР

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС ХОЛБОО БАРИХ:

 75551919, 99907664, 88004829

 boardsecretary@qpay.mn